



23

УЛААНБААТАР
хотын Ардын Депутатуудын хурлын
Гүйцэтгэх Захиргааны
ТОГТООЛ

Улаанбаатар хот

1973 оны II дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 227

Бүтээгдсэн

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ.

ТЗ-ийг 1990 оны 110 дугаар тогтоолоор хүчингүй

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаанаас **ТОГТООХ** нь:

I. Улаанбаатар хотын ахуй-ундны усны эх булгийн ариун цэврийн хамгаалалтын бүсийн дүрмийг баталсугай.

/ дүрмийг хавсаргав /

2. Энэ дүрмийн дагуу ахуй-ундны усны ариун цэврийн хамгаалалтын бүсийг 1973 онд багтаан тогтоохыг районуудын АДХ-ын Гүйцэтгэх Захиргаа, ариун цэвэр халдвар судлалын станц, Ус сувгийн ашиглалтыг эрхлэх газарт даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ

ӨРЛӨГЧ ДАРГА *[Signature]* Ю.ЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧ-

ГИЙН ДАРГА *[Signature]* Д.ДАМДИНСҮРЭН

24

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх
Захиргааны 1978 оны II-р сарын 22
ны өдрийн 227 дугаар тогтоолоор
батлав.

УЛААНБААТАР ХОТЫН АХУЙ УНДНЫ УС
ХАНГАМЖИЙН ЭХ БУЛАГИЙН АРИУН ЦЭВРИЙН
ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ДҮРЭМ.

Нэг. Ерөнхий зүйл.

1. БНМАУ-ын ус ашиглалтын хууль, ундны усны ариун цэврийн дүрмийг биелүүлэх, усны нөөц баялагийг бохирдол, хордлого, хоргодлоос хамгаалах зорилгоор Улаанбаатар хотын ахуй ундны ус хангамжийн эх булагт ариун цэврийн хамгаалалтын бүсийг ахуй ундны ус хангамжийн эх булгийн ариун цэврийн хамгаалалтын бүсийн дүрмийн дагуу тогтооно.
2. Улаанбаатар хотын ахуй ундны ус хангамжийн эх булгийн ариун цэврийн хамгаалалтын бүсийн дүрэм нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хамгийн дотор мөрдөгдөнө.
3. Энэ дүрмийг Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа ус ашиглагч бүх байгууллага, ард иргэд даган мөрдөнө.
4. Ус хангамжийн системд ажиллагсад эрүүл мэндийн дэвтэр авч биеийн эрүүл мэндийн бүрэн шинжилгээ хийлгэх ба урьдчилан сэргийлэх үзлэгийн зааврын дагуу эрүүл мэндийн үзлэг шинжилгээг тогтоосон хугацаанд заавал хийлгэж, хувийн ариун цэврийн шаардлагыг байнга сахин биелүүлнэ.
5. Энэхүү дүрмийн биелэлтэнд Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны усны аж ахуйн хэлтэс, хотын АЦХС Станц хяналт тавина.
6. Ариун цэврийн хамгаалалтын бүсийн хэмжээ хязгаарыг усны эх булаг, хөрсөн дэх уст давхраа, оршиж байгаа хэсгийн ариун цэврийн нөхцөл байдал болон гидрогеологийн шинэ, хуучигч хөрсний бүрэлдэхүүн, газрын доорхи усны урсгалын чиглэл, ус ашиглалт, шахалтаас үүссэн буурцын хүнхийн хигээсийн хэмжээ усны хөдөлгөөнт ба тогтонги төвшин, ченарын хувьсал, гадаргын усны урсгал, давалгааны байдал, салхины зонхилох чиглэл, бохирдлын эх үүсвэрийн нөлөөлөлийн хир хэмжээ зэргийг харгалзан районы АДХ-ын Гүйцэтгэх Захиргаа, хотын АЦХС станц, ус сувгийн ашиглалтыг эрхлэх газар, ус ашиглагч байгууллагын мөргөжлийн хүмүүсийн бүрэлдэхүүнтэй комиссоос тогтооно.

Хоёр. Цэвэр усны эх булгийн ариун цэврийн
хамгаалалтын хатуу дэглэмийн нэг-
дүгээр бүс.

7. Ус хангамжийн системийн ус чуул ба чуул бүс баяаг бохирдох, хордох, хорөгдохоос хамгаалах зорилгоор хатуу дэглэмийн нэгдүгээр бүсийг тогтооно.

8. Ахуй ундны усны эх булгийн ариун цэврийн хамгаалалтын хатуу дэглэмийн нэгдүгээр бүс нь ус хангамжийн эх булгийн ус олзворлох ерөмдмөл худаг, хөөргийн станц, усны сан ус цэвэрлэх, халдвартгүйжүүлэх төхөөрөмж, байгууламж ус авах төхөөрөмжийн хүрээнд байгаа ус дамжуулагч шугам хоолой, түгээх цэг салбарт тогтоогдоно.

9. Хотын цэвэр усны хангамжийн ус олзворлох ерөмдмөл худгуудын ариун цэврийн хамгаалалтын хатуу дэглэмийн нэгдүгээр бүсийг

а/ Найрамдлын району ус хангамжийн нэгдүгээр өргөгчид: 1550 м х 100 м = 155000 м² = 15,5 га;

б/ Үйлдвэрийн району ус хангамжийн нэгдүгээр өргөгчид: 1464 м х 100 м = 14640 м² = 14,64 га;

в/ Мах комбинатын ус хангамжийн нэгдүгээр өргөгчид: 1500 м х 100 м = 15000 м² = 15 га; талбайтайгаар тус тус тогтооно.

10. Хотын ус хангамжийн өргөгчөөр барих усны эх булагт ариун цэврийн хамгаалалтын хатуу дэглэмийн нэгдүгээр бүсийг зураг төслийн дагуу өргөтгөн тогтооно.

11. Ариун цэврийн хамгаалалтын хатуу дэглэмийн нэгдүгээр бүсийг төвлөрсөн ус хангамжийн хөөргийн станц, усны сан, ус цэвэрлэх, халдвартгүйжүүлэх төхөөрөмж, байгууламж болон ус авах төхөөрөмжийн хүрээнд байгаа ус дамжуулах хоолой, түгээх нэг салбарын захын цэвээс 50 м-ийн зайтайгаар тогтооно.

12. Төвлөрсөн бус ус хангамжийн ус ундны хэрэгцээнд ариун цэврийн байгууллагаар зөвшөөрөгдсөний үндсэн дээр ариун цэврийн хамгаалалтын хатуу дэглэмийн нэгдүгээр бүсийг ус олзворлох ерөмдмөл, уурхайн худгийн тэнхлэг, булгаас ус авах хамлагын эргэн тойрон, 50 м зайд, хэрэв ус олзворлох худгийн буурцын хунхийн хигээсний дундаж хэмжээ нь 50 м-ээс их байвал хигээсний хэмжээгээр усны сан, ус олгох, түгээх байрны эргэн тойронд 30 м-ээр тус тус тогтооно.

Турав. Ариун цэврийн хамгаалалтын хоёрдугаар бүс.

13. Ашиглагдаж байгаа буюу ашиглахаар төлөвлөж байгаа

уст давхрааг элдэв бохирдлоос хамгаалахын тулд түүний орчны ариун цэвэр, гидростеологийн нөхцөл байдлыг харгалзан тодорхой хязгаарын дотор ус хангамжаас бусад зүйлд ашиглахыг хориглосон ариун цэврийн хамгаалалтын хоёрдугаар бүс тогтооно.

14. Ариун цэврийн хамгаалалтын 2-р бүсийг уст давхраа нь ямар гүнд оршиж байгааг үл харгалзан ус хангамжийн бүх эх булагт тогтоож мөрдүүлнэ.

15. Уст давхраа нь гол мөрөн, нуур цөөрөм зэрэг газар дээрхи устай ус тэнгээл зүйн холбоотой байвал д тэдгээр усан сангийн тодорхой хэсгийг ариун цэврийн хамгаалалтын хоёрдугаар бүсэнд оруулна.

16. Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн ус олзворлох өрөмдмөл худгуудын ариун цэврийн хамгаалалтын хоёрдугаар бүсийг ариун цэврийн хамгаалалтын нэгдүгээр бүсээс гадагш 150-200 м-т тогтооно.

17. Туул голын усыг төвлөрсөн ус хангамжинд шууд авч ашиглаагүй нөхцөлд ариун цэврийн хамгаалалтын хоёрдугаар бүсийн дээд хязгаарыг "У" булангаар, доод хязгаарыг Шувуу фабрикаар, Сэлбэ голыг хотын төвөөс дээш 28 км, Гачууртын голын Туул голд цутгаж байгаа төгсгөлөөс дээш 10 км, Толгойтын баруун зүүн салааг Туулд цутгах төгсгөлөөс дээш 3 км, Их Тэнгэр, бага тэнгэр, Зайсангийн ам, Хүрхрээ, Залаат, Нүхт, Арцадын амны горхи, Налайхын хөндийн гол, Төрхурах, Чулуут голыг уртын нь хэмжээгээр хажуугийн бүсийг голын хоёр талын эргээс 200 метрээр тус тус тогтооно.

Дөрөв. Ариун цэврийн хамгаалалтын хатуу дэглэмийн нэгдүгээр бүсэд авах арга хэмжээ.

18. Төвлөрсөн ус хангамжийн ариун цэврийн хамгаалалтын хатуу дэглэмийн нэгдүгээр бүсийн эргэн тойрон 2 метрийн өндөр өргөст торон хашаа барьж шөнийн цагт бүрэн гэрэлтүүлэх ба ус олзворлох худаг, усны сан нь автомат удирдлага бүхий хяналтын нэгдсэн систем, утсан харилцууртай болгож бүх нутаг дэвсгэр, харагдах өндөрлөгдсөн цэгт 24 цагийн харуул хамгаалалттай байлгана.

19. Ариун цэврийн хамгаалалтын нэгдүгээр бүсийн орчныг бүрэн цэвэршүүлэн тэгшиж зүлэгжүүлэх, мод цөцөрлөг ургуулах, зам, талбайг эвсэж цөмийтлөх зэргээр тохижуулсан байна.

20. Гадаргуугийн бохир шингэн урсацыг ариун цэврийн

Хамгаалалтын нэгдүгээр бүсэнд шингэн орохоос хамгаалж ус нэвтрэхгүй доторлогос бүхий суваг, хоолойг бүсээс гадарш гаргаж байгуулсан байвал зохино.

21. Ариун цэврийн хамгаалалтын нэгдүгээр бүсийн дэвсгэрийн барилга байгууламж нь бохир усны татуургын системд заввал холбогдсон байна. Хэрэв тийм боломж хангагдаагүй бол бохир усны нүх, бие засах газрын хана, ёроолыг ус нэвтрүүлэхгүйгээр тусгаарлаж, бохир шингэмийг зөөвөрлөхдөө орчны газрын хөрсөн дээр асгаж бохирдуулахаас сэргийлэн, тээврийн хэрэглүүр, зорсох талбайг нүхний эмсартай хамт бетондаж тохижуулсан байвал зохино.

22. Хатуу дэглэмийн нэгдүгээр бүсэд ойролцоо байрласан үйлдвэр, аж ахуй, орон сууцны барилга байгууламж нь дэвсгэр нутгийн хувьд бүрэн зааглагдаж орчин нь ямар нэг бохирдолт үүсгэхгүйгээр тоноглогдон тохижигдсон байна.

23. Ус хангамжийн барилга байгууламжийн ашиглалтын үед хийгдэх өргөтгөл, засварын ажлыг гагцхүү ариун цэвэр, халдвар судлалын хяналтын байгууллагын зөвшөөрөл, хяналттайгаар батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэнэ.

24. Ус хангамжинд зориулан өрөмдөөд ашиглаагүй бэлгээ цооногийг бөх бат таглан гагнаж ломбодсон байна.

25. Газрын дээрхи усны эх булагт тогтоогдсон ариун цэврийн хамгаалалтын нэгдүгээр бүсэд байгаа усны урсгалыг зөв зохицуулан гулдирыг хашиж тохижуулсан байна.

26. Ариун цэврийн хамгаалалтын хатуу дэглэмийн нэгдүгээр бүсийн нутаг дэвсгэр дээр доорхи зүйлүүд үйлдэхийг хатуу хориглоно.

а/Төр, барилга байгууламж, барьж оршин суух

б/Мал болон бусад амьтадыг байрлуулж, билчээрлүүлэх услах, зөгсө барих, усанд шумбах.

в/Аливаа гаралтай хог хаягдал, бохир усыг асгах

г/Газрын хөрсөнд шим, эрдэс бордоо хэрэглэх газрын хөрсөн дээр химийн хорт бодис, нефтийн бүтээгдэхүүн болон бусад бохирдуулах зүйл байрлуулах, асгах.

д/Газрын өнгөн хөрсний эрүүл байдлыг алдагдуулж гэмтээх аливаа ажиллагаа явуулах.

е/Ус хангамжийн системд ажиллагсад, улсын ариун цэврийн хяналтын байгууллагын байцаагчид болон нэвтрэх эр-

хийн үнэмлэх бүхий хүмүүсээс бусад гадныг хүнийг зөвшөөрөл-
гүй оруулах.

Тэв.Ариун цэврийн хамгаалалтын хоёрдугаар
бүсэд авах эргэ хэмжээ

27.Эвдрэл,гэмтлийн улмаас зохисгүй ашиглаж байгаа
буюу огт ашиглаагүй байгаа хуучин худаг цооногийг сэргээн
засаж усны чанарыг стандартад тохиртол сейкруулан ашиглана.

Сэргээн засаж ашиглахгүй, боломжгүй нөхцөлд ус давх-
рааны хамгаалалтын байдлыг анхных нь хэмжээнд хүртэл сайж-
руулж ариун цэвэр, гидрогеологийн шаардлагыг хангасны дараа
дарах хэрэгтэй.

28.Ашиглаж байсан буюу ашиглагдаж байсан бохир ус
шингээгч нүх, цооногыг илрүүлэн халдваргүйтүүлж дарсан байх
ёстой.

29.Шинээр худаг гаргах болон барилгын аливаа үйл ажил-
лагааг ариун цэвэр, халдвар судлалын хяналтын байгууллагын
зөвшөөрөлтэйгөөр гүйцэтгэнэ.

30.Ариун цэврийн хамгаалалтын 2-р бүсийн дэвсгэрт
байгаа үйлдвэр, үйлчилгээ, хүн амын оршин суух газрыг зөв
зохион байгуулагдсан цэвэр, бохир усны байгууламжтай болгох,
малын хашаа, хэвтэр, бохир усны нүх, ердийн бие засах газрын
бохир ялгадас, шингэнийг хөрсөнд шингэхээс хамгаалсан хашилт
хамгаалалт хийхээс гадна хөрсний гадаргын бохирдсон урсцыг
зайлуулах, хамгаалалтын доторлогоо бүхий суваг татаж тохи-
жуулсан байна.

31.Ариун цэврийн хамгаалалтын 2-р бүсэд хамаарагдах
усны эх булаг, түүний сав газарт үйлдвэр, аж ахуйн бохир
шингэнийг урсгах хэрэгцээ гарвал урьдчилан цэвэрлэж, халдвар-
гүй болгосны дараа ариун цэврийн норм шаардлагыг хангасан
нөхцөлд галтхүү улсын ариун цэврийн хяналтын байгууллагын
зөвшөөрөлтэйгөөр гүйцэтгэнэ.

32.Ариун цэвэр хамгаалалтын 2-р бүсийн нутаг дэвсгэр
дээр доорхи зүйлүүд үйлдэхийг хатуу хориглоно.

а/Уст давхарааны дээрхи хөрсний өнгөн давхаргыг
эвдэх, элс хайрга, хөрс, зүлэг эвч ашиглах.

б/дарах шаардлагатай хуучин худаг, цооногын
усыг гал унтраах ба аж ахуй, техникийн хэрэгцээнд ашиглахаар
үлдээх.

в/Ариун цэврийн хамгаалалтын 2-р бүсэд
хамаарагдах газрын хөрс, түүн дээр орших усны эх булгийг

үйлдвэр, барилгын хатуу хог, хаягдал, бохир шингэн, элдэв ялгадсаар бохирдуулах.

г/Шинээр орон сууц, аж ахуй, үйлчилгээний болон үйлдвэрлэлийн барилга байгууламж байгуулах, зуслангийн айлуудыг байрлуулах.

д/Ариун цэврийн хамгаалалтын бүсэд элдэв мэрэгчид шавьж баялгах.

е/Ариун цэврийн хамгаалалтын 2-р бүсэд усан авто хэрэгсэл угаах, малаас хүнд халдах халдварт евчтэй мал билчээрлүүлэх, услах зэргээр дэвсгэрийг ашиглах.

33. Ариун цэврийн хамгаалалтын 2-р бүсэд доор дурьдсан зүйлүүдийг хамруулж хяналт тавина.

а/Ус хангамжийн эх булаг түүнээс усыг авах ба цэвэрлэх, халдваргүйтүүлэх төхөөрөмж, хаергийн станц болон ус түгээх шугам, цэг салбарууд

б/Ус хангамжийн эх булгийн ундрата, түүний сэлээ, цутгалууд болон усны хэмжээ, чанарт муугаар нөлөөлж болзошгүй усны бүсэд эх булаг ба хөрсний ус

в/ус хангамжийн эх булагт тодорхой нөлөө үзүүлж болох барилга байгууламж, үйлдвэр аж ахуйн газар, хүн амын оршин суух газрыг орчных нь дэвсгэрийн хамт.